



МОНГОЛ
УЛСЫН
ЗАСГИЙН
ГАЗАР

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2020 I-IX

ГАРЧИГ

1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ	1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл.....	1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	2
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.....	4
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар.....	4
2.1.3. Газрын тосны салбар	4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн	7
2.4. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад.....	8
3. ГАДААД ХУДАЛДАА.....	9
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	9
3.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	10
3.1.2. Хүнд үйлдвэрийн салбар.....	11
3.1.3. Газрын тосны салбар	11
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт.....	11
3.2.1. Хүнд үйлдвэрийн салбар.....	12
3.2.2. Газрын тосны салбар	12

1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020		Зөрүү	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзлэх хувь
			Төлөвлөгөө (Тодотгол)	I-IX сар		
1	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	36,000.0	19,868.0	16,132.0	55.2%
2	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	1,352.6	1,020.7	331.9	75.5%
3	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	8,700.0	6,252.5	2,447.5	71.9%
4	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан) ¹	тн	24.0	17.1	6.9	71.4%
5	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.бар	4,300.0	2,379.7	1,920.3	55.3%
6	Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ²	мян.тн	141.8	102.7	39.1	72.4%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ³	мян.тн	799.4	490.7	308.7	61.4%

Эх сурвалж: Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Монголбанк

1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 7,316.6 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1,340.0 тэрбум төгрөг буюу 15.5 хувиар буурсан байна.

Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 1,412.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 734.8 тэрбум төгрөг буюу 34.2 хувиар буурсан байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхайн салбараас 1,316.3 тэрбум төгрөг буюу 18.0 хувь,
- Газрын тосны салбараас 61.9 тэрбум төгрөг буюу 0.8 хувь,
- Тусгай зөвшөөрлийн төлбөр 25.2 тэрбум төгрөг буюу 0.3 хувь,
- Бусад орлого 9.2 тэрбум төгрөг буюу 0.1 хувь.

Эрдэс баялгийн салбар⁴ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 19.3 хувийг бүрдүүлж байна.

¹ Монголбанканд тушаасан алтны мэдээлэл болно. Тус дүнд мөнгөний мэдээлэл ороогүй болно.

² Цайр нь МУ-ын 2020 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

³ Хайлуур жонш нь МУ-ын 2020 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

⁴ Эрдэс баялгийн салбар гэдгийг Уул уурхай, газрын тосны салбараар энэхүү статистик мэдээлэлд оруулсан болно.



Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Гүйцэтгэлийн өөрчлөлт	
		2019	2020 (Тодотгол)	2019 I-IX	2020 I-IX	Зөрүү	Хувь
Нийт дүн		3,404.1	2,857.3	2,147.5	1,412.6	-734.8	-34.2%
УУЛ УУРХАЙН САЛБАР							
Нийт дүн		3,000.0	2,698.1	1,923.0	1,316.3	-606.7	-31.5%
1	Алт	83.0	212.6	30.5	122.5	92.0	301.3%
2	Зэс	1,304.0	1,127.7	803.9	646.5	-157.5	-19.6%
3	Нүүрс	1,311.0	1,056.3	933.0	396.4	-536.6	-57.5%
4	Бусад	302.0	301.5	155.6	151.0	-4.6	-3.0%
ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР							
5	Газрын тос	335.6	110.0	172.1	61.9	-110.3	-64.1%
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО							
Нийт дүн		68.5	49.2	52.3	34.4	-17.8	-34.1%
6	Тусгай зөвшөөрлийн төлбөр	42.9	30.0	28.7	25.2	-3.5	-12.3%
7	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2.3	6.6	4.2	6.7	2.5	60.4%
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/	11.3	9.0	15.5	0.0	-15.4	-99.7%
9	Бусад орлого	12.0	3.6	4.0	2.5	-1.4	-36.5%

Эх сурвалж: Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 – дахин их

1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр улсын төсөвт 1,316.3 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 646.5 тэрбум төгрөг,
- Нүүрс 396.4 тэрбум төгрөг,
- Алт 122.5 тэрбум төгрөг,
- Төмөр 55.8 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 53.0 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 21.9 тэрбум төгрөг,
- Цайр 20.3 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 606.7 тэрбум төгрөг буюу 31.5 хувиар буурсан байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Алт 92.0 (4.0 дахин их) тэрбум төгрөг,
- Төмөр 37.0 (3.0 дахин их) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 536.6 (57.5%) тэрбум төгрөг,
- Зэс 157.5 (19.6%) тэрбум төгрөг,
- Цайр 37.4 (64.8%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 2.3 (9.4%) тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 2.0 (3.7%) тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019		2020		Өөрчлөлт			
	IX	I-IX	IX	I-IX	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	104.8	1,923.0	198.6	1,316.3	93.9	89.6%	-606.7	-31.5%
Алт	3.7	30.5	20.3	122.5	16.5	5.4 ¹	92.0	4.0 ¹
Нүүрс	60.3	933.0	62.2	396.4	1.9	3.2%	-536.6	-57.5%
Цайр	2.0	57.7	1.4	20.3	-0.6	-30.3%	-37.4	-64.8%
Зэс	28.6	803.9	95.1	646.5	66.5	3.3 ¹	-157.5	-19.6%
Төмөр	1.3	18.8	8.4	55.8	7.1	6.3 ¹	37.0	3.0 ¹
Хайлуур жонш	1.8	24.2	4.0	21.9	2.2	2.2 ¹	-2.3	-9.4%
Бусад	6.9	55.0	7.2	53.0	0.3	4.0%	-2.0	-3.7%

Эх сурвалж: Сангийн яам

Тайлбар: 1 – дахин их



2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.1. Уул уурхай, олборлох салбар

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 22.9 сая тн нүүрс, 940.7 мян.тн зэсийн баяжмал, 14,880.3 кг алт, 4,220.1 тн молибдений баяжмал, 57.0 мян.тн хайлуур жоншны хүдэр, 100.1 мян.тн хайлуур жоншны баяжмал, 6,766.5 мян.тн төмрийн хүдэр, 3,620.3 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 55.3 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад алт 3,862.8 кг буюу 35.1 хувь, молибдений баяжмал 396.2 тн буюу 10.4 хувь, төмрийн хүдэр 352.6 мян.тн буюу 5.5 хувь, төмрийн хүдрийн баяжмал 1,188.5 мян.тн буюу 48.9 хувь, хайлуур жоншны хүдэр 21.4 мян.тн буюу 60.3 хувь, хайлуур жоншны баяжмал 4.8 мян.тн буюу 5.0 хувиар тус тус өссөн байна.

Харин нүүрс 15.7 сая тн буюу 40.7 хувь, зэсийн баяжмал 24.0 мян.тн буюу 2.5% хувь, цайрын баяжмал 7.2 мян.тн буюу 11.5 хувиар тус тус буурсан байна.

2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1.5 сая тн баяжуулсан нүүрс, 290.4 мян.тн нүүрсэн шахмал түлш, 6.9 мян.тн катодын зэс, 15.1 мян.тн металл бэлдэц, 13.1 мян.тн металл цувимал, 4.2 мян.тн ган төмөр хийц, 63.2 тн цахилгааны утас тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсэн шахмал түлш 105.4 мян.тн буюу 56.9 хувиар, цахилгааны утас 0.1 тн буюу 0.1 хувиар тус тус өссөн байна.

Харин баяжуулсан нүүрс 1.1 сая тн буюу 41.4 хувь, катодын зэс 2.1 мян.тн буюу 23.5 хувь, металл бэлдэц 6.6 мян.тн буюу 30.5 хувь, металл цувимал 10.4 мян.тн буюу 44.3 хувь, ган төмөр хийц 2.4 мян.тн буюу 36.5 хувиар тус тус буурсан байна.

2.1.3. Газрын тосны салбар

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 2,445.7 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад газрын тос 2.7 сая бар буюу 52.3 хувиар буурсан байна.



Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2019		2020		Өөрчлөлт			
			IX	I-IX	IX	I-IX	(5-3)=?, (5/3)=%		(6-4)=?, (6/4)=%	
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1. Уул уурхай, олборлолт										
1.1	Нүүрс	мян.тн	4,766.7	38,583.7	4,890.8	22,884.8	124.1	2.6%	-15,698.9	-40.7%
1.2	Газрын тос	мян.бар	570.3	5,125.0	550.4	2,445.7	-19.9	-3.5%	-2,679.3	-52.3%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	84.8	964.7	106.2	940.7	21.4	25.2%	-24.0	-2.5%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	480.7	3,823.9	339.7	4,220.1	-141.0	-29.3%	396.2	10.4%
1.5	Алт	кг	1,525.5	11,017.5	2,241.6	14,880.3	716.1	46.9%	3,862.8	35.1%
1.6	Төмрийн хүдэр, баяжмал:	мян.тн	1,351.4	8,845.7	1,561.6	10,386.8	210.2	15.6%	1,541.1	17.4%
	- Төмрийн хүдэр	мян.тн	977.0	6,413.9	1,119.6	6,766.5	142.6	14.6%	352.6	5.5%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	374.4	2,431.8	442.0	3,620.3	67.6	18.0%	1,188.5	48.9%
1.7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал:	мян.тн	15.2	130.8	19.2	157.1	4.0	26.6%	26.2	20.1%
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	1.3	35.6	4.2	57.0	2.9	3.1'	21.4	60.3%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	13.8	95.3	15.0	100.1	1.2	8.4%	4.8	5.0%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	6.6	62.5	6.8	55.3	0.2	3.2%	-7.2	-11.5%
2. Боловсруулах үйлдвэр										
2.1. Хүнд үйлдвэр										
2.1.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	443.9	2,627.5	321.5	1,540.3	-122.4	-27.6%	-1,087.2	-41.4%
2.1.2	Нүүрсэн шахмал түлш	тн	12,750.0	185,072.9	39,156.0	290,430.0	26,406.0	3.1'	105,357.2	56.9%
2.1.3	Катодын зэс, 99%	тн	743.7	8,980.3	694.6	6,873.4	-49.1	-6.6%	-2,106.9	-23.5%
2.1.4	Металл бэлдэц	тн	1,695.9	21,749.3	3,621.8	15,113.0	1,925.9	2.1'	-6,636.3	-30.5%
2.1.5	Металл цувимал	тн	3,312.2	23,586.7	2,372.0	13,144.2	-940.2	-28.4%	-10,442.5	-44.3%
2.1.6	Ган төмөр хийц	мян.тн	1.1	6.6	0.4	4.2	-0.7	-66.8%	-2.4	-36.5%
2.1.7	Цахилгааны утас	тн	7.0	63.2	8.6	63.2	1.7	23.9%	0.1	0.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их

2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2019		2020		Өөрчлөлт			
	IX	I-IX	IX	I-IX	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,563.7	13,386.0	1,659.0	11,081.5	95.3	6.1%	-2,304.5	-17.2%
Уул уурхай, олборлолт	1,137.8	9,694.4	1,225.0	7,607.8	87.2	7.7%	-2,086.6	-21.5%
Нүүрс олборлолт	529.6	4,173.2	431.7	1,968.4	-97.9	-18.5%	-2,204.8	-52.8%
Газрын тос олборлолт	84.9	762.6	54.9	259.0	-30.0	-35.3%	-503.6	-66.0%
Металлын хүдэр олборлолт	506.1	4,463.4	714.2	5,089.0	208.0	41.1%	625.6	14.0%
Бусад ашигт малтмал олборлолт	11.4	108.9	20.4	168.0	9.0	78.7%	59.1	54.3%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	5.7	186.3	3.8	123.4	-1.9	-33.5%	-62.9	-33.8%
Боловсруулах үйлдвэр	331.1	2,752.0	346.6	2,527.0	15.5	4.7%	-225.0	-8.2%
Үүнээс, хүнд үйлдвэр	119.6	834.6	138.0	754.3	18.3	15.3%	-80.3	-9.6%
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	55.4	360.3	63.9	309.1	8.5	15.3%	-51.3	-14.2%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7.4	83.6	8.6	62.7	1.2	16.2%	-20.9	-25.0%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	30.3	205.5	37.8	203.6	7.5	24.6%	-1.9	-0.9%
Металл боловсруулах үйлдвэрлэл	24.1	178.4	27.0	176.6	3.0	12.3%	-1.8	-1.0%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2.4	6.7	0.6	2.4	-1.8	-74.3%	-4.4	-64.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 11.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 (17.2%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 7.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 (21.5%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 2.2 (52.8%) их наяд төгрөг, газрын тос олборлолт 503.6 (66.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Харин металлын хүдэр олборлолт 625.6 (14.0%) тэрбум төгрөг, бусад ашигт малтмал олборлолт 59.1 (54.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 68.7 хувийг эзэлж байна.

2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2019		2020			Өөрчлөлт			
	IX	I-IX	IX	I-IX	Гад-дад	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,683.0	15,531.4	1,944.7	12,666.9	7,129.1	261.7	15.6%	-2,864.5	-18.4%
Уул уурхай, олборлолт	1,141.7	10,735.8	1,378.7	8,177.9	5,919.9	237.0	20.8%	-2,557.9	-23.8%
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	485.1	4,006.0	496.5	1,890.0	1,673.2	11.3	2.3%	-2,115.9	-52.8%
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	82.1	720.0	54.8	242.3	242.3	-27.3	-33.3%	-477.7	-66.3%
Металлын хүдэр олборлолт	529.3	5,620.2	796.2	5,687.4	3,877.0	266.8	50.4%	67.2	1.2%
Бусад ашигт малтмал олборлолт	15.9	148.9	27.5	185.2	127.4	11.7	73.5%	36.3	24.4%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	29.3	240.8	3.8	173.0	-	25.5	-87.0%	-67.8	-28.2%
Боловсруулах үйлдвэр	446.5	3,853.8	478.4	3,537.8	1,209.3	31.9	7.1%	-316.0	-8.2%
Үүнээс, хүнд үйлдвэр	209.7	1,649.4	237.1	1,384.1	984.2	27.4	13.1%	-265.3	-16.1%
Кокс, газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	123.4	1,020.2	151.0	738.5	707.0	27.6	22.4%	-281.7	-27.6%
Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.5	98.9	10.4	72.9	-	1.9	22.3%	-26.0	-26.3%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	34.7	217.4	45.9	252.1	-	11.2	32.2%	34.7	15.9%
Металл боловсруулах үйлдвэрлэл	40.8	306.2	29.0	318.2	276.1	-11.7	-28.8%	12.0	3.9%
Машин, ТТ-өөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2.3	6.7	0.7	2.4	1.2	-1.6	-68.0%	-4.3	-64.5%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 (18.4%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 8.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (23.8%) их наяд төгрөгөөр буурахад чулуун, хүрэн нүүрс олборлолт 2.1 (52.8%) их наяд төгрөг, газрын түүхий тос, байгалийн хий олборлолт 477.7 (66.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлөв.

Харин металлын хүдэр олборлолт 67.2 (1.2%) тэрбум төгрөг, бусад ашигт малтмалын олборлолт 36.3 (24.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 7.1 их наяд төгрөг буюу 56.3 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 5.9 их наяд төгрөг буюу буюу 83.0 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.



2.4. АЖҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

хүнээр

Салбар	2017	2018	2019	2020	Өөрчлөлт			
	I-IX сар				(5-3)=?, (5/3)=%		(5-4)=?, (5/4)=%	
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	71,021	76,074	80,865	78,547	2,473	3.3%	-2,318	-2.9%
Уул уурхай, олборлолт	24,631	24,493	25,943	24,195	-298	-1.2%	-1,748	-6.7%
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	7,189	8,190	7,948	7,246	-944	-11.5%	-702	-8.8%
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	2,473	1,613	1,547	1,398	-215	-13.3%	-149	-9.6%
Металлын хүдэр олборлолт	13,055	12,847	14,417	13,773	926	7.2%	-644	-4.5%
Бусад ашигт малтмал олборлолт	1,914	1,843	1,905	1,763	-80	-4.3%	-142	-7.5%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа			126	15	15	#DIV/0!	-111	-88.1%
Боловсруулах үйлдвэр	29,638	32,031	34,118	33,043	1,012	3.2%	-1,075	-3.2%
Үүнээс, хүнд үйлдвэр	3,714	5,710	6,356	6,065	355	6.2%	(291)	-4.6%
Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл								
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	186	510	880	926	416	81.6%	46	5.2%
Металл боловсруулах үйлдвэрлэл	2,903	3,206	3,210	3,151	-55	-1.7%	-59	-1.8%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	337	1,887	1,971	1,883	-4	-0.2%	-88	-4.5%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их

3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 9.1 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.5 тэрбум ам.доллараар буюу 13.9 хувиар буурсан байна. Экспорт импортоос давамгайлж 1.2 тэрбум ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

сая ам.доллар

Үз-лт	Жилээр			Өөрчлөлт				I-IX сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	%	Дүн	%				Дүн	%	Дүн	%
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	9,634	10,545	9,075	911	9%	-1,470	-14%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	5,283	5,946	5,147	663	13%	-799	-13%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	4,351	4,599	3,928	248	6%	-671	-15%
Тэнцэл	1,865	1,137	1,493	-728	-39%	356	31%	932	1,347	1,219	416	45%	-128	-10%

3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 4.8 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 533.7 сая ам.доллараар буюу 10.0 хувиар буурсан байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 93.6 хувийг эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2019	2020	Өөрчлөлт	
		I-IX сар		Өсөлт/бууралт	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	85.0	74.5	-10.6	-12.4%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,332.7	1,142.6	-190.1	-14.3%
Түүхий нефть болон газрын тос	бар/ам.дол	56.1	36.1	-20.0	-35.7%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	68.8	74.1	5.2	7.6%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,441.2	1,209.1	-232.2	-16.1%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	310.2	235.3	-74.8	-24.1%
Молибдений хүдэр, баяжмал	тн/ам.дол	8,784.7	6,490.4	-2,294.2	-26.1%
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	кг/ам.дол	46,121.1	57,595.2	11,474.1	24.9%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3.1.1. Уул уурхай, олборлох салбар

Чулуун нүүрсний экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1.5 тэрбум ам.долларын 19.8 сая тн чулуун нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 958.8 сая ам.доллараар буюу 39.4 хувиар, биет хэмжээгээр 8.8 сая тн-оор буюу 30.8 хувиар тус тус буурсан байна. 1 тн чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 74.5 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 10.6 ам.доллараар буюу 12.4 хувиар буурсан байна. Чулуун нүүрсний 96.0 хувийг БНХАУ руу, 2.5 хувийг Сингапур руу, 1.5 хувийг Их Британи руу тус тус гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1.2 тэрбум ам.долларын 1.0 сая тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 254.7 сая ам.доллараар буюу 17.9 хувиар, биет хэмжээгээр 45.5 мян.тн-оор буюу 4.3 хувиар тус тус буурсан байна. 1 тн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1,142.6 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 190.1 ам.доллараар буюу 14.3 хувиар буурсан байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу гаргасан байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 463.3 сая ам.долларын 6.3 сая тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 41.0 сая ам.доллараар буюу 9.7 хувиар, биет хэмжээгээр 118.2 мян.тн-оор буюу 1.9 хувиар тус тус өссөн байна. 1 тн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 74.1 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.2 ам.доллар буюу 7.6 хувиар өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу гаргасан байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 115.5 сая ам.долларын 490.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 9.2 мян.тн-оор буюу 1.9 хувиар, үнийн дүнгээр 39.6 сая ам.доллараар буюу 25.5 хувиар тус тус буурсан байна. 1 тн хайлуур жоншны экспортын дундаж үнэ 235.3 ам.доллар болж, 74.8 ам.доллар буюу 24.1 хувиар буурсан байна. Хайлуур жоншны 76.1 хувийг БНХАУ руу, 23.6 хувийг ОХУ руу, 0.3 хувийг БНСУ руу тус тус гаргасан байна.

Цайрын баяжмалын экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 124.2 сая ам.долларын 102.7 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.0 мян.тн-оор буюу 2.0 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 20.9 сая ам.доллараар буюу 14.4 хувиар буурсан байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,209.1 ам.доллар болж, 232.2 ам.доллар буюу 16.1 хувиар буурсан байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу гаргасан байна.

Молибдений баяжмалын экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 29.9 сая ам.долларын 4.6 мян.тн молибдений баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 7.3 сая ам.доллараар буюу 19.6 хувиар буурсан ч, биет хэмжээгээр 370.8 тн-оор буюу 8.8 хувиар өссөн байна. 1 тн молибдений баяжмалын экспортын дундаж үнэ 6,490.4 ам.доллар болж, 2,294.2 ам.доллараар буюу 26.1 хувиар буурсан байна. Молибдений баяжмалын 83.6 хувийг БНХАУ руу, 16.4 хувийг БНСУ руу тус тус гаргасан байна.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1.2 тэрбум ам.долларын 20.2 тн алт экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 821.9 сая ам.доллараар буюу 3.4 дахин их, биет хэмжээгээр 12.8 тн-оор буюу 2.7 дахин их тус тус өссөн байна. 1 кг алтны экспортын дундаж үнэ 57,595.2 ам.доллар болж, 11,474.1 ам.доллар буюу 24.9 хувиар өссөн байна. Алтны 90.0 хувийг Швейцар руу, 5.4 хувийг Сингапур руу, 4.6 хувийг Их Британи руу тус тус гаргасан байна.

3.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

Коксын экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 409.7 мян.ам.долларын 2.4 мян.тн кокс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 18.1 сая ам.доллараар буюу 97.8 хувиар, биет хэмжээгээр 91.7 мян.тн-оор буюу 97.5 хувиар тус тус буурсан байна.

Катодын зэс: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 33.5 сая ам.долларын 6.2 мян.тн катодын зэс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1.3 мян.тн-оор буюу 17.2 хувиар, үнийн дүнгээр 9.9 сая ам.доллар буюу 22.9 хувиар тус тус буурсан байна.

3.1.3. Газрын тосны салбар

Газрын тосны экспорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 86.0 сая ам.долларын 2.4 сая бар газрын тос экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.5 сая бар-иар буюу 50.9 хувиар, үнийн дүнгээр 185.8 сая ам.доллар буюу 68.4 хувиар тус тус буурсан байна. 1 бар газрын тосны экспортын дундаж үнэ 36.1 ам.доллар болж, 20.0 ам.доллараар буюу 35.7 хувиар буурсан байна.

3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр импорт 3.9 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 670.7 сая ам.доллараар буюу 14.6 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт 728.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 288.9 сая ам.доллараар буюу 28.4 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2019	2020	Өөрчлөлт	
		I-IX сар		Өсөлт/бууралт	Хувь
Автобензин	тн/ам.дол	599.0	417.6	-181.3	-30.3%
Дизель түлш	тн/ам.дол	615.6	423.0	-192.6	-31.3%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3.2.1. Хүнд үйлдвэрийн салбар

Коксын импорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 115.5 мян.ам.долларын 628.9 тн кокс импортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 854.3 тн-оор буюу 57.6 хувиар, үнийн дүнгээр 145.7 мян.ам.доллараар буюу 55.8 хувиар тус тус буурсан байна.

3.2.2. Газрын тосны салбар

Эрдэс бүтээгдэхүүний импортын 80.1 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна. 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 583.3 сая ам.долларын 1.3 сая тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 45.7 мян.тн-оор буюу 3.3 хувиар, үнийн дүнгээр 274.8 сая ам.доллар буюу 32.0 хувиар тус тус буурсан байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импорт үнийн дүнгийн 82.3 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 30.1 хувийг автобензин, 52.2 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 175.8 сая ам.долларын 421.0 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 23.8 мян.тн-оор буюу 6.0 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 62.1 сая ам.доллараар буюу 26.1 хувиар буурсан байна. 1 тн автобензины импортын дундаж үнэ 417.6 ам.доллар болж, 181.3 ам.доллараар буюу 30.3 хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт: 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 304.5 сая ам.долларын 720.0 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 202.9 сая ам.доллараар буюу 40.0 хувиар, биет хэмжээгээр 104.2 мян.тн буюу 12.6 хувиар тус тус буурсан байна. 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ 423.0 ам.долларт болж, 192.6 ам.доллараар буюу 31.3 хувиар буурсан байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ